



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/ЗН1

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай" 194 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Онгийн голын байнгын хяналтын цэг, Хархорин сумын Орхон голын гүүрийн түр хяналтын цэг, Туркийн замын байнгын хяналтын цэг, Тарнын гүүрийн байнгын хяналтын цэг, Нарийнтээл сумын байнгын хяналтын цэгүүдийн хяналтын постуудад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Хяналтын постод 2020 оны 12 дугаар сарын 04-14-ний өдрийн хооронд ажиллах алба хаагчдын хоол хүнс, шатахууны зардалд зарцуулах 3,660,000 (гурван сая зургаан зуун жаран мянга) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс(Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Онцгой байдлын газар, дэд хурандаа (Д.Одонбаяр)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101229

Аймгийн Засаг даргын 2020 оны 12
дугаар сарын 11-ны өдрийн 17/СЗД
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хяналтын постод үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын хоолны мөнгө	30	4 хоног	12000	1,440,000
2	Шатахуун	литр	800	1,400	1,120,000
3	Тусгаарлалтад байрласан албан хаагчид	11 хүн	2 хоног	50,000	1,100,000
Нийт дүн					3,660,000

-оОо-